



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!


№102 /546/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.06.23

Цаг үе, үйл явдал

ОХУ-ЫН ЭЛЧИН САЙД НОЁН А.Н.ЕВСИКОВЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ




Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Алексей Николаевич Евсиковыг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ноён А.Н.Евсиковыг Элчин сайдаар томилогдсон явдалд баяр хүргэж, хоёр улсын уламжлалт батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өндөр түвшинд амжилттай амжилттай хөгжиж буйг тэмдэглэв. Цаашлаад ирэх жил тохиох Халх голын байлдааны ялалтын 85 жилийн ойг хамтран тэмдэглэх асуудлаар болон цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар талууд санал солилцлоо.

Элчин сайд А.Н.Евсиков Батлан хамгаалахын сайдтай биечлэн уулзаж байгаадаа талархал илэрхийлж цаашид хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд анхааран ажиллахаа мэдэгдэв.




ЭЛЧИН САЙД КИМ ЖОН ГҮГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ким Жон Гүг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ноён Ким Жон Гүг элчин сайдаар томилогдсонд баяр хүргээд, олон жилийн найрамдалт харилцаатай хоёр улсын харилцаа олон салбарт амжилттай хөгжиж буйг тэмдэглэв. Цаашлаад батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар талууд харилцан санал солилцлоо.

Элчин сайд Ким Жон Гүг, Батлан хамгаалахын сайдтай биечлэн уулзаж байгаадаа баяртай байгаагаа илэрхийлж, цаашид хоёр орны харилцаа, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд анхаарч ажиллахаа мэдэгдэв.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,429	3,436
EUR 🇪🇺	3,738	3,778
CNY 🇨🇳	484	487
RUB 🇷🇺	39	40,30
JPY 🇯🇵	24	24.50
KRW 🇰🇷	2.25	2.40

ЗУРХАЙ



2023.06.23 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 5

ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХАР ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал, арвижна

Наран ургах, шингэх:

04.53-20.55

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

САНСАР

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдно.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ЖОЛООНЫ "А" АНГИЛЛЫН ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТДАА АМЖИЛТТАЙ ХАМРАГДЛАА



ЗХЖШ-ын даргын 2023 оны А/168 дугаар тушаалын дагуу хугацаат цэргийн алба хаагчдад Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, алба хаах хугацаанд нь жолооч бэлтгэх сургалтыг зохион байгуулах чиглэлээр Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба, Зэвсэгт хүчний 011 дүгээр анги, Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвтэй хамтран Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн 48 хугацаат цэргийн алба хаагчдыг жолооны "А" үндсэн ангиллын дамжаанд хамруулан энэ оны 06 дугаар сард төгсөлтийн шалгалтыг амжилттай зохион байгууллаа.

Үндсэн "А" ангиллын жолооны сургалтад тус ангийн 48 хугацаат цэргийн алба хаагч хамрагдаж, "Замын хөдөлгөөний дүрэм"-ийн болон жолоодлогын шалгалтад тэнцсэн байна.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,602,456

Эдгэрсэн

Нийт: 663,051,678

Нас барсан

Нийт: 6,892,124

Цахим шууданд

Ж.БОЛДБААТАР:ОЮУТАН ЦЭРЭГ СУРГАЛТЫН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ, НЭР ХҮНД НИЙГЭМД АСАР ӨНДӨР БАЙНА



тавьж, оюутан цэргүүдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, биеийн жингийн зохистой харьцааг хангах, сэтгэл зүйг тогтвортой байлгах, дархлаажуулах, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх

-Аливаа эрсдэлийг тооцож, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулж байх

-Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ил задгай гал түлэхгүй байх, тамхины цэгийг байгуулах, шаардлагатай тохиолдолд ашиглах галын хор болон бусад гал унтраах багаж хэрэгслийг агуулах, гал тогоо, тавиуланд байршуулж, галын эргүүлийг ажиллуулах

-Бороо хур элбэгтэй үед үерийн аюулаас сэргийлж, цаг агаарын мэдээг тогтмол авч бие бүрэлдэхүүнд сэрэмжлүүлэн анхааруулж, алба хаагчдыг гол мөрөн, нуур цөөрөм гатлах, усанд орохыг хориглох

-Зэвсэг техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тэдгээрийн бүрэн бүтэн байдал, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, галт хэрэглэлийн хайрцаг, сав, баглаа, боодлыг нэг бүрчлэн үзэж, шалгаж байх, мөн бүртгэл тооцоог сайжруулан, тавиулан, агуулах, ажлын байр бүрд анхааруулга, санамжийг байрлуулан, цэргийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг ханган, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг хэрэгжүүлэх

-Хууль тогтоомж, дүрэм журам зааврыг холбогдох албан тушаалтнуудад судлуулах, таниулах сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг тодорхой давтамжтайгаар зохион байгуулж байх

-“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” тухай хууль, “Цэргийн нийтлэг дүрмүүд”, “Цэргийн албыг зохион байгуулах заавар”-ыг хатуу чанд мөрдөж сахилга дэг журмыг чангатгах

-“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, Батлан хамгаалахын сайдын 2015 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан “Зэвсэгт хүчний анги байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавих шаардлагатай байна хэмээсэн юм.

Өнөөдөр Батлан хамгаалахын Ерөнхий шалгагч бригадын Ж.Болдбаатар тэргүүтэй холбогдох албаны удирдлага, мэргэжилтнүүд “Оюутан цэргийн мэргэжлийн боловсрол олгох сургалт”-ын хэргийн гаралтыг зохион байгуулж буй анги, салбаруудын албан тушаалтнуудтай цахимаар хуралдлаа.

Энэ үеэр Батлан хамгаалахын Ерөнхий шалгагч бригадын Ж.Болдбаатар хэлсэн үгэндээ “Монгол Улсын Ерөнхий сайд энэ хавар оюутнуудтай уулзах үеэр залуучуудын гаргаж тавьсан 10 асуудлын нэг нь оюутан цэргийн тоог нэмэгдүүлэх хүсэлт байсан. Холбогдох судалгааг хийж, засгийн газрын шийдвэрээр 160 оюутан хамрагдах байсныг 1500 болгож нэмэгдүүлсэн. Энэ нь Оюутан цэрэг гэх эл сургалтын эрэлт хэрэгцээ болоод нэр хүнд нийгэмд асар өндөр буйг харуулж байна. Батлан хамгаалахын сайд “Оюутан цэргийн мэргэжлийн боловсрол олгох сургалт”-ыг зохион байгуулах ажлын үйл явцад онцгой анхаарал хандуулж ажиллахыг үүрэг болгосон. Үүний дагуу оюутан цэргүүдийн сургалт бэлтгэлийн

үйл явц, норм хангалтын түвшин ямар байгаа мэдээллийг сонсохоор өнөөдөр та бүхэнтэй цахимаар хурлыг зохион байгуулж байна” хэмээлээ.

Хурлаар “Оюутан цэргийн мэргэжлийн боловсрол олгох сургалт”-ыг зохион байгуулж буй нэгтгэл, анги, байгууллагууд тус бүр 5 минутын хугацаанд цахимаар холбогдож өдөр тутмын цэргийн сургалт, бэлтгэлийн үйл явц, норм хангалт, цэргийн алба хаагчдын сэтгэл зүй болон эрүүл мэндийн байдлыг танилцуулсан юм.

Холбогдох албан тушаалтнуудын хэлж буйгаар Оюутан цэргүүдийн биеийн байдал болон сэтгэлзүй тогтвортой байгаа бөгөөд одоогоор цэргийн албанд дасгах бэлтгэл сургуулалтдаа хамрагдаж байгаа аж.

Хурлын төгсгөлд Батлан хамгаалахын Ерөнхий шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар “Оюутан цэргийн мэргэжлийн боловсрол олгох сургалт”-ын хэргийн гаралтыг зохион байгуулж буй холбогдох албан тушаалтнуудад дараах үүрэг чиглэлийг өгч хатуу мөрдлөг болгон ажиллахыг санууллаа.

-Бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдалд байнгын хяналт

“ЗАМ-2023” ХОЁР ҮЕ ШАТТАЙГААР АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний инженерийн салбаруудын хамтарсан “Зам-2023” сургалт, дадлага хоёр үе шаттайгаар амжилттай явагдаж өндөрлөлөө.

Сургалт, дадлагын хаалтын арга хэмжээнд Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяаши Хироюки, Япон Улсын Хуурай замын цэргийн дэд дарга, дэслэгч генерал Кобаяаши Хироки, Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Ирики Ёохэй болон сургалт, дадлагад хамрагдсан хоёр улсын 50 гаруй цэргийн инженер оролцов.

Ч.Цогтжаргал Монгол Улс, Япон Улсын Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж шинэ агуулгаар баяжин өргөжиж байгааг дурдаж, хамтарсан “Зам” сургалт, дадлагыг улам өргөжүүлнэ гэдгээ онцоллоо.

Мөн Япон Улсын Хуурай замын цэргийн командлалын дэд дарга, дэслэгч генерал Кобаяаши Хироки Монгол, Япон цэргийн инженерүүд харилцан туршлага солилцох, авто зам, авто замын ус зайлуулах байгууламжийн зураг төслийг боловсруулах, барих чадвар дадлагыг нэмэгдүүлэхэд энэхүү сургалтын ач холбогдол оршиж байгааг тодотгож, эхэлсэн цагаасаа хойш үр дүнтэй явагдаж байгааг нь хаалтын ёслолын төгсгөлд илэрхийллээ.

Энэ үеэр бригадын генерал

Ахмад Г.МӨНХБОЛД



ОЮУТАН ЦЭРГҮҮД ОЮУН УХААН, ХҮЧ ЧАДЛААРАА ӨРСӨДЛӨӨ



БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 167 дугаар ангийг түшиглэн говийн бүсийн аймгуудын “Оюутан цэрэг” сургалтын цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж байна.


Сургалтад хамрагдаж буй оюутан цэргүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, өдөр тутмын цагийн хуваарийн дагуу соёл хүмүүжлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Төлөвлөгөөний дагуу цэргийн дүрэм, Монголын түүх, танин мэдэхүйн сэдвээр асуулт, хариултын “АХА” тэмцээн, “Олс таталт”-ын аварга

шалгаруулах тэмцээнүүдийг зохион явуулахад “АХА” тэмцээний тэргүүн байрт Өмнөговь аймгаас татагдан алба хааж буй I мотобуудлагын салааны байлдагч П.Чинболор, дэд байрт Дундговь аймгаас татагдан алба хааж буй байлдагч Т.Буяннэмэх нар мэдлэг, оюун ухаанаараа бусдыгаа манлайлав.

Харин багаар ажиллах чадвар, хүч чадал, тэсвэр тэвчээрээ сорьсон олс таталтын тэмцээнд байлдагч Б.Ууганбаатар ахлагчтай I мотобуудлагын салааны баг тамирчид тэргүүн байр, байлдагч Ш.Сүрлэг ахлагчтай II мотобуудлагын салааны баг тамирчид хамт олноо манлайлан амжилттай оролцсон юм.

Ахлах дэслэгч Б.БАТЗАЯА



Санамж



Зэвсэгт хүчний
Жанжин штаб



Цагдаагийн
ерөнхий газар

**ЖОЛООЧ ДАРААХ
БИЧИГ БАРИМТЫГ
ШАЛГУУЛАХ
ҮҮРЭГТЭЙ**



ЗАМЫН
хөдөлгөөний
ДҮРЭМ

1



Жолоодох эрхийн хүчинтэй үнэмлэх

ЗХД-ийн 3.1 дэх заалт

2



Тээврийн хэрэгслийн гэрчилгээ

3



Жолоочийн даатгалын баталгаа

4



Ачааны болон бусад баримт бичиг

5



Тулгуур эрхтний бэрхшээлтэйг нотлох бичиг



Дарга дэд хурандаа

САЙНБОЛДЫН
УУГАНБААР

ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний
Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” редакц



“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шууданд:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)